

ХКН-ЫН XII ИХ ХУРЛЫН ТУХАЙ**М. Зэнээ**

1982 оны 9-р сарын 1-нээс 11-нд ХКН-ын XII их хурал Бээжин хотод болов. Их хурлын үйл ажиллагаанд нийтдээ 1600 гаруй төлөөлөгчид оролцлоо. ХКН-ын XII их хурал Төв Хорооны тайлан илтгэл, намын дүрмийн шинэ төсөл, намын сахилга батыг шалгах төв комиссын ажлын тайлан зэргийг хэлэлцэн баталж, төгсгөлд нь сонгууль явууллаа.

Их хурлыг ХКН-ын Төв Хорооны орлогч дарга Дэн Сяопин товч үг хэлж нээв. Тэрээр «энэ удаагийн их хурал ХКН-ын VII их хурлаас хойш болж буй хамгийн чухал их хурал» юм гэж дурдаад 1956 онд хуралдсан ХКН-ын VIII их хурлын чиг шугам зөв байсан гэдгийг тэм- дэглэсэн боловч түүний шийдвэр «социализм байгуулах үзэл санааны бэлтгэл намд дутагдалтай байсан учир биелэгдээгүй юм»¹ гэж тайлбарлажээ.

БНХАУ-ын өмнө тулгарч байгаа 80-аад оны гурван гол зорилтыг Дэн Сяопин «Улс орондоо сониалист шинэчлэлтийг хэрэгжүүлэх, Тайванийг багтаасан нэгдмэл эх орноо байгуулах, жанжлалыг эсэргүүцэж дэлхийн энх тайвныг хамгаалах явдал» гэж тодорхойлоод энэ гол гурван зорилтоос хамгийн чухал нь «эдийн засгийн асуудал, тэр нь «Хятад улсын дотоод гадаад асуудлыг шийдвэрлэх суурь нь» гэж тэмдэглэжээ.

ХКН-ын XII их хурлын тайлан илтгэлийг Намын Төв Хорооны ерөнхийн нарийн бичгийн дарга Ху Яобан хийлээ. Тайлан илтгэл үндсэн 6 хэсэгтэй. 1-р хэсэгт «Энэ удаагийн их хурлын зорилт бол өнгөрсөн 6 жилийн ялалтыг дүгнэж, 10 жилийн самуурлаас үлдсэн муу уршгийг арилган социалист шинэ нийгэм байгуулах»² явдал гэж тодорхойлов. Үзэл суртлын хувьд «..бид удаан хугацааны турш оршсоор ирсэн догматизм нэг хүнийг тахин шүтэх явдлын хүлээсийг эрс таслан»³ «нам төрийн удирдах бүрэлдэхүүнийг аажмаар цэгцэлж чангатгав» гэсэн байна. Илтгэгч хятадын нам төр, эдийн засаг, соёл, шинжлэх ухаанд урт хугацааны турш ноцтой бэрхшээл учруулсан гол зүйлүүдийн нэгийг Мао Зэдуныг тахин шүтэж, «зүүний алдаанд» хэт автагдсан явдал гэж тодорхойлжээ. Ху Яобан «нам, төрийн ажлын голыг эдийн засгийн асуудалд шилжүүлж тэнд урт хугацаанд оршиж ирсэн «зүүний алдааг» арилгаснаар социалист шинэчлэлтийг хэрэгжүүлэх»⁴ эрүүл замд бид орж байна гэв. Мөн энэ хэсэгт «соёлын хувьсгал» болон «зүүний алдааны» тухай авч ярихдаа түүнд Мао Зэдуны нас өндөр болох үедээ хийсэн алдаа холбогдоцо»⁵ гэсэн боловч «Мао Зэдун хятадын хувьсгалд баларшгүй аугаа их хувь нэмэр оруулсан» болохоор одоо ч хойшид ч «..нам ард түмний дотор эрхэм дээд

1. «Жэньминь жибао» 1982. IX. 2.

2. «Жэньминь жибао» 1982. IX. 8.

3. Мөн тэнд.

4. Мөн тэнд.

5. «Жэньминь жибао» 1982. IX. 2.

илтгэл хүндтэй» хэвээр байх ба «Мао Зэдуны үзэл санааг эрс хамгаална»⁶ гэжээ.

Илтгэлийн 2-р хэсэгт эдийн засгийн асуудлыг хөндөв. «1981 оноос энэ зууны эцэс хүртэл 20 жилд..» улс орны эдийн засгийг хөгжүүлэх явдлыг нам онцгой анхаарах болно гэж илтгэгч тэмдэглэв. «1981-1985 оны VI таван жилд эдийн засгийг тохируулах, өөрчлөх цэгцлэх дээшлүүлэх чиг шугамыг үргэлжлүүлэн, бүрэлгэн сүйтгэхийн эсрэг гамин аривлах замаар үр ашгийг нэмэгдүүлэх ба «1986-1990 он хүртэлх VII таван жилд эдийн засаг техникийн бүтцийг үндсэнд нь өөрчлөн байгуулах»⁷ болно гэдэг зорилт дэвшүүлжээ. Хөдөө аж ахуйг хөгжүүлэх явдал улс ардын аж ахуйг хөгжүүлэх гол зангилгаа асуудал гэж илтгэгч цохон тэмдэглээд одоо Хятадад «хүн ам ихдэж, газар багадсан зөрчил улам их болж байна. Иймээс хойшид хүн амын өсөлтийг чанга хязгаарлаж, энэ зууны эцэс гэхэд хятадын хүн амыг нэг миллиард хоёр зуун саяас хэтрүүлэхгүй «бөгөөд» төлөвлөгөөтэй төрөх явдлыг өчүүхэн ч сулруулж болохгүй» гэж хэлжээ.

Ху Яобан илтгэлийнхээ 3-р хэсэгт социалист оюун санааны соёлын тухай, 4-р хэсэгт социалист ардчилалын тухай ярьжээ.

Илтгэгч «Мөлжигч анги ангийн хувьд утсаны дараа нийгмийн гол зөрчил ангийн тэмцэл биш болсон боловч тэрээр зарим нөхцөлд хурцдаж ч болно»⁸ гэжээ. Ху Яобан үүнийг батлахын тулд одоо хятад оронд зүйл зүйлээр дайсагнагч этгээд эдийн засаг, улс төр соёл боловсрол нийгмийн амьдралын бүх хүрээнд социалист нийгмийн байгуулалтыг зориуд дайсагнан түлхэн унагаахыг оролдож байна. Ийм дайсагнагч этгээдтэй тэмцэх ард түмний тэмцэл бол манай улсын одоогийн ангийн тэмцлийн гол илрэл мөн»⁹ гэжээ.

Илтгэлийн 4-р хэсэгт «эдийн засгийг сайтар хөгжүүлсний үндсэн дээр батлан хамгаалалтыг эрс сайжруулах» тухай яриад «хятадын армийг шинэчлэн хүчирхэг болгох, өрхийн цэргийн зохион байгуулалтыг улам сайжруулах»¹⁰ явдал онцгой ач холбогдолтой гэж тэмдэглэв.

Ху Яобан илтгэлийнхээ V хэсгийг гадаад бодлогын асуудалд зориулав. «Энх тайвнаар зэрэгцэн орших 5 зарчмын үндсэн дээр социалист орнуудыг багтаасан бүх улс оронтой цаашид харьцаагаа хөгжүүлнэ» гэж БНХАУ-ын гадаад бодлогын үндсэн-чиглэлийг тодорхойлов. БНХАУ байгуулагдсанаас хойшхи 30 гаруй жилд «Мао Зэдун, Чжоу Эньлайн тогтоож өгсөн гадаад бодлогыг» хэрэгжүүлж ирсэн учир Хятадын олон улсын нэр хүнд өссөн гэж тэмдэглээд социалист шинэ хятад улс «гадаадын ямарч улсаас алгын чинээ газарч эзэлж байгаагүй»¹¹ гэлээ.

Илтгэгч хөгжиж байгаа орнуудтай харилцах асуудалд гадаад бодлогынхоо голыг чиглүүллээ. «Гурав дахь ертөнц гарч ирсэн явдал дэлхийн II дайнаас хойшхи хамгийн том үйл явдал мөн гэж үзээд «Хятадын эдийн засаг хөгжих тутам гурав дахь ертөнцийн орнуудтай харилцах манай харилцаа цаашид улам бэхжих болно. Бидний хоорондын харилцаа хөгжингүй орнуудтай харилцах харилцаанаас давуу юм гэж хэлсэн байна.

Хятад -америкийн харилцааны талаар илтгэгч «хоёр улс 1979 онд дипломат харилцаа албан ёсоор тогтоосон» гээд Америкаас Тайваньд зэвсэг нийлүүлж байгааг шүүмжилсэн байна. Мөн Японтой харилцах тухайд Японд милитаризм сэргэж байгаад сэтгэл түгшиж байгаагаа илтгэгч дурджээ.

6. Мөн тэнд.

7. Мөн тэнд.

8. Мөн тэнд.

9. «Жэньминь жибао» 1982. IX. 8.

10. ХКН-ын XII их хурлын тайлан илтгэл, Бээжин 1982. 57-р тал

11. «Жэньминь жибао» 1982. IX. 8

Хятад-зөвлөлтийн харилцааны талаар илтгэгч ярихдаа «хоёр улс удаан хугацаанд найрамдалтай байв. Гэвч өнөөдөр ийм байдалд хүрсэн нь Зөвлөлтөөс болсон»¹² гээд Зөвлөлтийн удирдагчид хоёр улсын харилцааг хэвийн болгох хүсэлтэй гэж мэдэгдэж байна. Бид анхааралдаа авлаа. Хоёр улсын харилцааг сайжруулах нь хоёр орны ард түмний эрх ашигт нийцнэ гэжээ.

ЗХУ-ын зүгээс Хятадад ямар ч аюул занал учруулж байгаагүй бөгөөд ЗХУ, БНХАУ-д нутаг дэвсгэрийн буюу өөр ямарваа шаардлага тавьж байгаагүй¹³ юм. ЗХУКН Зөвлөлт засгийн газар хоёр улсын харилцаа хэвийн биш байдалд орсон анхны үеэс эхлэн дээд хэмжээнд уулзалт хийх тухай, хүч үл хэрэглэх болон харилцан үл довтолох гэрээ байгуулах, улс хоорондын харилцааг хэвийн болгон сайжруулах тухай хэлэлцээ хийх¹⁴ зэрэг олон чухал санал, санаачлагуудыг дэвшүүлж «хятадын ард түмнийг хүндэтгэж, эв найрамдалтай байх манай сэтгэл хувиршгүй хэвээр байгаагийн нэг адил Хятадтай харилцаагаа хэвийн болгоход чиглэсэн Зөвлөлтийн санал хүчинтэй хэвээр байна»¹⁵ гэдгээ цаг ямагт илэрхийлсээр ирсэн билээ.

Зөвлөлт, хятадын харилцааг сайжруулах нь зөвхөн энэ хоёр орны төдийгүй, Ази тив, даян дэлхийн энх тайван аюулгүй байдлыг бэхжүүлэхэд туйлын чухал ач холбогдолтой гэдгийг ЗХУ иш үндэс болгож БНХАУ-тай харилцаагаа хэвийн болгохыг ийнхүү хүсч байгаагаа удаа дараа мэдэгдэж байгааг дэлхий нийтээр мэдэх билээ. Гэхдээ хоёр орны харилцааг хэвийн болгоход гуравдахь орны эрх ашгийг хөндөхгүй байх ЗХУ-ын зарчимч саналд хятадын тал хэрхэн хандахыг хятадтай хил залгаа улс орнууд анхааралтай харж байна.

1981 онд хуралдсан МАХН-ын Төв Хорооны V бүгд хурал дээр МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга н. Ю.Цэдэнбал «Монгол-хятадын харилцааг социализм, энх тайвны эрх ашигт нийцсэн зарчмын үндсэн дээр хэвийн болгож болно гэсэн тууштай байр суурийг манай орон баримталсаар байгааг батлан хэлэхийг хүсч байна»¹⁶ гэж мэдэгдсэн нь улс хоорондын харилцааны хэв хэмжээг ямагт хүндэтгэн сахиж ирсэн манай улсын энх тайванч гадаад бодлогын бас нэг яруу тод илрэл боллоо.

Ху Яобан тайлан илтгэлийн VI хэсгийг намын удирдах үүрэгтэй холбон ярив. Түүхэн шинэ нөхцлөөс болж намын нэр хүнд, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор «ХКН-ын их хурлаар баталсан намын дүрэмд ач холбогдол бүхий нилээд засвар» оруулж хойшид «намын гишүүдэд тавих шаардлагыг улам чангаруулах болно» гэж уг хэсэгт дурьджээ.

Илтгэлийн сүүлийн хэсэгт «намын шинэ дүрэм нь XI их хурлаар баталсан намын дүрэм дэх «зүүний» алдааг арилгаж, ХКН-ын VII, VIII их хурлаар баталсан намын дүрмийн сайн талыг сонгон авч хөгжүүлсэн» гэж тодорхойлоод «хувь хүнийг ямар нэг хэлбэрээр тахин шүтэх явдлыг хатуу хориглоно» гэсэн заалт намын дүрэмд оруулсныг онцлон тэмдэглэв.

Нам, засгийн газарт хийсэн өөрчлөлтийн тухай илтгэгч хэлэхдээ «Зохион байгуулалтыг өөрчлөх ажлын анхны алхам нам, засгийн төв аппаратад үндсэндээ биеллээ», «муж, хот, өөртөө засах орнуудад 1983 оны эхээс эхлэн¹⁷ «зохион байгуулалт, үзэл суртлын цэгцлэлт» хийнэ гэдгийг илтгэгч анхааруулав.

12. «Жэньминь жибао» 1982. IX. 8.

13. Правда. 1982. Y. 20.

14. Мөн тэнд .

15. Правда. 1982. Y. 20.

16. «Үнэн» 1981. 12. 8

17. XII Все китайский съезд КПК. Пекин. 1982.

9-р сарын 6-ны бүгд хуралдаан дээр ХКН-ын XII их хурлын тайлан илтгэл, түүний тогтоол, мөн шинэ дүрмийг батлав.

9-р сарын 10-ны бүгд хуралдаан дээр ХКН-ын Төв Хорооны жинхэнэ гишүүнээр 210, Зөвлөхүүдийн төв комиссын гишүүнээр 172 хүн тус тус сонгогдлоо.

9-р сарын 11-нд хурал ажиллагаагаа дуусгасан бөгөөд сүүлчийн хуралдаан дээр ХКН-ын сахилга батыг шалгах төв комиссын ажлын тухай тогтоолыг батлаад мөн Төв Хорооны орлогч гишүүнээр 138 хүн, сахилга батыг шалгах төв комиссын гишүүнээр 132 хүн тус тус сонголоо.¹⁸

9-р сарын 12-нд ХКН-ын Төв Хорооны 12-р удаагийн анхдугаар бүгд хурал болж ХКН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоог 25 гишүүн, 3 орлогчтойгоор сонгов. ХКН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны байнгын хорооны 6 гишүүний бүрэлдэхүүнд Ху Яобан, Жао Зыян, ахмадуудаас Е Зяньин, Дэн Сяопин, Ли Сяньнянь Чэнь Юнь нар сонгогдлоо. ХКН-ын Төв Хорооны Цэргийн зөвлөлийн даргаар Дэн Сяопин нарыг тус тус сонгожээ.